

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ

2021.09.01

Тодорхойлолт:

Умайн хүзүүний өмөн - Умайн хүзүүний олон давхар хучуур эс ба сувгийн нэг эгнээ бортгон эсүүдээс гаралтай хорт хавдар.


Умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэг бол умайн хүзүүний олон давхар хучуур эд, сувгийн нэг эгнээ бортгон эсийн **гаж хувирал (дисплази)**. Энэхүү гаж хувиралыг дотор нь:

- Хөнгөн хэлбэрийн дисплази – CIN I
- Дунд зэргийн дисплази – CIN II
- Хүнд хэлбэрийн дисплази ба бүрхүүл эдийн хүрээнд дэх өмөн – CIN III гэж ангилна.

Умайн хүзүүний хорт хавдрын эмнэл зүй:


- Өвчний эрт үед илрэх өвөрмөц шинж тэмдэг илрэхгүй
- Үтрээнээс гарах цагаан юмны хэмжээ, өнгө, үнэр өөрчлөгдөж цусархаг болно
- Бэлгийн харьцааны дараа болон үзлэгийн үед умайн хүзүүнээс цус гарах
- Хожуу үед өвдөлт өгнө, турах, ядрах, хоолны дуршил сулрах зэрэг ерөнхий сульдлын шинж тэмдгүүд илрэнэ

Зураг 1. Умайн хүзүүний өөрчлөлт



Умайн хүзүүний тархвар зүй

Зураг 2. Global Cancer Observatory 2018 /GLOBOCAN/ 185 улс орны умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн стандартчилсан түвшин ДЭМБ-ын мэдээлэл. The Lancet. February 01, 2020



Дэлхийд:

- 100 000 эмэгтэй тутамд умайн хүзүүний өмөн 13.1 тохиолдол (2-75 тохиолдол)
- Эмэгтэйчүүдийн дунд дөрөв дахь байранд

Монголд:


- Умайн хүзүүний өмөн 15-44 насны эмэгтэйчүүдийн дунд тэргүүлж байснаа 45-59 насанд хоёрдугаар байрт орж байна.
- Эмэгтэйчүүдийн хавдрын дунд хоёрдугаар байранд – 11.9%
- 100 000 эмэгтэй тутамд умайн хүзүүний өмөн 22.7 тохиолдол

Эрсдэлт хүчин зүйлс:

- Бэлгийн харьцаанд эрт орох
- Бэлгийн олон хавьтагчтай байх
- Бэлгийн замын халдварт өвчнүүд
- Хүний Хөхөнцөр Вирусийн 16, 18, 33, 35, 58 хэв шинжийн /15-20 хэв шинж/ халдвар тээгчид
- Умайн хүзүүний өмөнгийн урьдал өвчнүүд

ХҮНИЙ ПАПИЛЛОМА БУЮУ ХҮНИЙ ХӨХӨНЦӨР ВИРУС

Зураг 3. Хүний папиллома вирусын бүтэц



- ДНХ-ийн хос гинж агуулсан вирус
- 200 гаруй хэв шинж илрүүлсэн
- 30-40 хэв шинжүүд бэлгийн замын халдварт өвчний шалтгаан болдог
- 15-20 хэв шинжүүд хорт хавдар үүсгэдэг (16,18,31,35,39,45,51,52,58)
- ХХВ-16 (54%) болон ХХВ-18 ийн (13%) халдвар нийт хүн амын дунд хамгийн их тархсан бөгөөд умайн хүзүүний өмөнгийн шалтгаан (68%)

Оношилгоо:

- Эс, эдийн шинжилгээ
- Үтрээн дуран (кольпоскопи)
- Бага аарцаг ба хэвлийн хөндийн эрхтний чанд авиан шинжилгээ
- Давсаг дурандах
- Шулуун гэдэс дурандах
- КТГ, МРТ, ПЭТ /позитрон эмиссион томографи/
- Тодосгогч бодистой бөөрний зураг авах

Ялган оношилгоо:

- Умайн хүзүүний ургацаг
- Умайн хүзүүний цагаарал
- Умайн хүзүүний жинхэнэ ба хуурамч шархлаа
- Умайн хүзүүний өмөнгийн суурь ба урьдал өвчнүүд

Умайн хүзүүний өмөнгийн эмчилгээ:

- **Мэс заслын эмчилгээ**

1. Умайн хүзүүний урьдал өвчний үед конизаци хийдэг. Конизацийг дараах 3 аргаар хийж болно. Үүнд:

а) **Мэс заслын хутган конизаци** (cold knife cone biopsy)

Зураг 4. Конизаци.




б) Лазер конизаци (laser conization)

Зураг 5. Лазер конизаци




в) Умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлж авах ажилбар. (The loop electrosurgical excision procedure, LEEP or LEETZ procedure)



2. Умайн хүзүүний өмөнгийн үе шатаас хамаарч энгийн экстирпаци, радикал гистерэктоми хийгддэг.
3. Трахелэктоми буюу нөхөн үржихүйн чадвар хадгалах мэс засал

Зураг. Трахелэктоми.



Заалт: Трахелэктоми мэс заслыг умайн хүзүүний өмөнгийн эрт үе шатанд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд сонголтоор.

- **Эмийн эмчилгээ**

Хими эмчилгээ: Цисплатин сууритай эмчилгээг ихэвчлэн туяа эмчилгээтэй хавсарч хийнэ.

- **Туяа эмчилгээ**

Туяа эмчилгээг анхдагчаар хими эмчилгээний хамт эсвэл умайн хүзүүний мэс заслын дараа хийдэг.

Заалт:

- ✓ Умайн хүзүүний өмөнгийн IA, IB1, IB2, IIA1 үе шатанд мэс заслын эмчилгээний эсрэг заалттай үед.
- ✓ Умайн хүзүүний өмөнгийн IB2 and IIA1 үе шатанд анхдагч эмчилгээ

- Хавсарсан туяа болон хими эмчилгээ

Заалт:

- ✓ Хэсэг газар тархсан умайн хүзүүний өмөнгийн IB3, II, III, IVA үе шатанд

Хүснэгт 1. Умайн хүзүүний хорт хавдрын үе шатны тавилан:

Үе шат	5 жилийн наслалт
Ia1	97,5%
Ia2	94,8%
Ib1	89,1%
Ib2	75,7%
IIa	73,4%
IIb	65,8%
IIIa	39,7%
IIIb	41,5%
IVa	22,0%
IVb	9,3%

Урьдчилан сэргийлэлт:

1. Анхдагч урьдчилан сэргийлэлт
 - Вакцинжуулалт (Gardasil 9, Cervarix) 9-14 насны өсвөр үеийн хүүхдүүдэд
2. Хоёрдогч урьдчилан сэргийлэлт
 - Нийт эмэгтэйчүүдийн хамарсан эрт илрүүлэг (скриннинг)
3. Гуравдагч урьдчилан сэргийлэлт
 - Умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгийн эмчилгээ

ХҮНИЙ ХӨХӨНЦӨР ВИРУСИЙН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТ

1) Вакцины нэршил: Cervarix

Human Papillomavirus Bivalent (Types 16 and 18) Vaccine, Recombinant

Үйлдвэрлэгч: GlaxoSmithKline Biologicals (Их британи)

Хэрэглэх заалт: 9-25 насны эмэгтэйчүүдэд хүний хөхөнцөр вирус 16, 18 хэв шинжийн шалтгаант умайн хүзүүний хорт хавдар, хавдрын урьдал өвчнөөс урьдчилан сэргийлэлт.

Хэрэглэх тун: 3 удаа. Нэг сарын дараа II тунг булчинд тарина, 5 сарын дараа III тунг хэрэглэнэ.

FDA батлагдсан огноо: Oct. 16, 2009

2) Вакцины нэршил: Gardasil 9

Human Papillomavirus 9-valent (Types 16, 18, 31, 33, 45, 52, 58, 6 and 11) Vaccine, Recombinant

Үйлдвэрлэгч: Merck and Co., Inc. USA

Хэрэглэх заалт: 9-45 насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэлт

- Умайн хүзүүний хорт хавдар
- Үтрээ, бэлгийн уруулын хорт хавдар
- Хошногоны хорт хавдар
- Зарим толгой хүзүүний байршлын хорт хавдар (хоолой, төвөнх, амны)
- Умайн хүзүү, бэлгийн уруулын, үтрээний хавдрын урьдал өвчин
- Бэлгийн үү өвчнөөс урьдчилан сэргийлэлт.

Хэрэглэх заалт: 9-45 насны эрэгтэйчүүд урьдчилан сэргийлэлт

- Хошногоны хорт хавдар
- Зарим толгой хүзүүний байршлын хорт хавдар (хоолой, төвөнх, амны)
- Хошногоны хавдрын урьдал өвчин
- Бэлгийн үү өвчнөөс урьдчилан сэргийлэлт.

Хэрэглэх тун: 2-3 удаа.

Насны ангилал	Хэрэглэх тун	Тунгийн давтамж
9-14 нас	2 тун	I тун: Эхний тун II тун: Эхний тунгаас 6-12 сарын зайтай
	3 тун	I тун: Эхний тун II тун: Эхний тунгаас хойш 2 сар III тун: Эхний тунгаас хойш 6 сар
15-45 нас	3 тун	I тун: Эхний тун II тун: Эхний тунгаас хойш 2 сар III тун: Эхний тунгаас хойш 6 сар


FDA батлагдсан огноо: Gardasil - June 8, 2006

Gardasil 9 - December 10, 2014

АВСТРАЛИ УЛСЫН ТУРШЛАГА

Австрали улсын умайн хүзүний өмөнгийн өвчлөл болон нас баралтын тоо нь эрт илрүүлэг болон вакцинжуулалтын үр дүнд эрс буурч Michaela T Hall et al. судлаачдын тооцоолсноор 20 жилийн дараа умайн хүзүүний өмөнгүй анхны улс болох өндөр магадлалтай.

1982 онд 100 000 эмэгтэйд 14.3 умайн хүзүүний хорт хавдрын тохиолдол, 1991 онд 13,3 тохиолдол бүртгэгдсэн бол 2016 онд энэ тоо 7,1 болж буурсан байна.



Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хөтөлбөр Австрали улсад 1991 оноос хэрэгжиж эхэлснээр 25-аас дээш насны эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл 50%-иар буурсан. Австрали улсын эрт илрүүлгийн хөтөлбөрт 18-69 насны эмэгтэйчүүдээс умайн хүзүүний эсийн шинжилгээг 2 жил тутамд авч байсан бөгөөд хамрагдалтын хувь нь 70,2-83,0% өндөр байсан. 2017 оноос хойш умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хөтөлбөрийн загварын өөрчлөн 25–69 насны эмэгтэйчүүдэд 5 жил тутамд HPV 16, 18 генотипийн шинжилгээ болон умайн хүзүүний эсийн шинжилгээг авч байгаа.

Австрали улс нь 2007 онд хүний хөхөнцөр вирусын эсрэг вакцинжуулалтыг үндэсний вакцинжуулалтын хөтөлбөрт оруулсан анхдагч улс болсон. Gardasil вакцины 3 тунгийг 12–13 насны охидуудад болон 2013 оноос хойш 12–13 насны хөвгүүдийг хамруулж байсан. 2018 оноос хойш Gardasil 9 вакцины 2 тунгийг тарьж эхэлсэн. Австрали улсын ХХВ-ийн хэв шинжийн судалгаагаар Gardasil 9 вакцин нь умайн хүзүүний хорт хавдрын 90%-аас хамгаалах бөгөөд өмнөх Gardasil тетравалент вакцинтай харьцуулахад 10%-иар илүү үр дүнтэй амьдралын туршид умайн хүзүүний өмөнгөөс хамгаална.

Ирээдүйд өсвөр насандаа Gardasil 9 вакцин тариулсан эмэгтэйчүүдэд зориулан умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хөтөлбөрийг өөрчлөх шаардлага гарна.

Ном зүй:

1. Jonathan S. Berek, Neville F. Hacker. Berek and Hacker's Gynecologic Oncology, 5th Edition
2. Авирмэд Д. Умайн хүзүүний эмгэг өөрчлөлтүүдийн оношлогоо эмчилгээ. Улаанбаатар 2005
3. Эмнэлзүйн удирдамж - 4. Умайн хүзүүний өмөн. Улаанбаатар 2011
4. Жон В. Селлорс, Р.Санкранараяан. Кольпоскопи ба умайн хүзүүний хучуурын шинэ гаж хувирлын эмчилгээ: Эхлэн суралцагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар 2003
5. Clark T. Johnson, Jennifer L. Hallock, Jessica L. Bienstock, Harold E. Fox, Edward E. Wallach. The Johns Hopkins Manual of Gynecology and Obstetrics, 5th Edition
6. Давыдов М.И, Кузнецов В.В, Летягин В.П. Опухоли женской репродуктивной системы. Медицинское информационное агенство; 2007
7. Бохман Ян Владимирович. Руководство по онкогинекологии. Медицина; 1989
8. Marc Arbyn, Elisabete Weiderpass, Laia Bruni et al. Estimates of incidence and mortality of cervical cancer in 2018: a worldwide analysis. The Lancet. Volume 8, Issue 2, E191-E203, February 01, 2020
9. The projected timeframe until cervical cancer elimination in Australia: a modelling study. Michaela T Hall, Kate T Simms, Jie-Bin Lew, Megan A Smith, Julia ML Brotherton, Marion Saville, Ian H Frazer, Karen Canfell. Lancet Vol 4 January 2019
10. 2021 Cervical cancer elimination progress report: Australia's progress towards the elimination of cervical cancer as a public health problem by the NHMRC Centre of Research Excellence in Cervical Cancer Control